

“ МОНГОЛ ШИЛТГЭЭН ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04-р сарын 30 өдөр

№ 25 / 01

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ МОНГОЛ ШИЛТГЭЭН ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал 2025.04.30-ны өдрийн 14.00 цагт УБ хот Чингэлтэй дүүрэг 2р хороо Самбуугийн гудамж “Орон зай” төв 7 давхарт 704 тоотод хуралдав.

Хуралд:

“ Монгол шилтгээн ” ХК –ийн хуралд хувьцаа эзэмшигч:

1. Таван толгой транс ХХК /3 532 125/ ширхэг
2. Ч.Амарбаатар /7.633 345/ ширхэг
3. Г.Ганчимэг /4.317 511/ширхэг
4. С.Долоонбаяр / 1 /ширхэг
5. Ж.Энхтунгалаг/ 25 /ширхэг
6. М.Отгонбаатар/ 1/ ширхэг
7. Н.Чимэдлхам /10/ ширхэг нарын хувьцаа эзэмшигч нар тус тус хуралд оролцов.

Хурал зохион байгуулах комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж компанийн нийт гаргасан 18. 620.690 ширхэг хувьцааны саналын эрхтэй хувьцааны тоог **15.483 018** ширхэг хувьцаагаар тогтоож хурлын ирц **83,14 %**тай байгааг мэдээлж компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэхийг тооллогын комисс зөвшөөрөв.

✓ Хурлын дарга Ч.Амарбаатар хурлыг нээж үг хэлэв.

Хурлаар:

- ✓ Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлт
- ✓ Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
- ✓ Компанийн үйл ажиллагааг 4 улиралд шилжүүлэх талаар танилцуулж нийт хувьцаа эзэмшигчдийн зүгээс санал авах, хөрөнгө мөнгөний боломж муутай байгаагаас шалтгаалан төлөвлөгдсөн ажлууд хойшилж байгааг дурьдав.

Хурлын дарга: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга: С.Дагиймаа ирцийг танилцуулан, тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 83,14 хувьтай байгаа тул КтХуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэв.

Хурал 14 цаг 15 минутад эхлэв.

СОНССОН НЬ:

Хурлын дарга: Ч.Амарбаатар Тооллогын комисс дүнгээ гаргаад хурал эхлүүлэх зөвшөөрөлийг олгож байна. Ингээд хурлын дэгээ танилцуулъя.

Хурлын хэлэлцэх асуудлын дагуу 2024 онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг гүйцэтгэх захирал танилцуулна.

Гүйцэтгэх захирал: М.Ган-Эрдэнэ

Үйл ажиллагааны тухайд:

2024 онд Монгол Шилтгээн ХК нь зуны 3 сард зочид буудал, зуслангийн зориулалтаар гэрүүдээ түрээслэн үйл ажиллагаагаа явуулан ажиллалаа.

2024 оны зун бороо ихтэй үер болсны улмаас Туул голын ус хальж Монгол Шилтгээний газар битүүдээ усанд автсан байдалтай байсны улмаас голын эрэг дээр болдог шоу наадмууд болоогүйгээс гадна залуучуудын хамгийн их сонирхож их хүн цугладаг Playtime шоу наадам цуцлагдан өөр газар хийдэг болсноос Монгол Шилтгээний зундаа олдог нилээн том орлого байхгүй болж зөвхөн гэрийн түрээсээс өөр орлогогүйгээр зуныг өнгөрөөлөө.

Гэвч гардаг зардлууд нь багасахгүй өрөө гэрүүдэд ус гоожин гэрийн бүрээс хучлага, хөшиг, дээвэр туургаас эхлээд бүгдийг солих, ус гоожсон байруудын дээвэрүүдийг янзлах, тааз обой солих, шал будах, гадна талыг будах шохойдох эмульсдэхээс авахуулаад, үерт нурсан хашааг шинэчилж хийх, цахилгааны шугамууд норж хуучирч элэгдсэний улмаас бүх газарт цахилгааны утасыг шинээр солих, усны шугам хоолой бас энд тэндгүй задарч солин, хавар намар болгон бүх цэвэр бохирын шугамуудыг цэвэрлэн сангийн хэрэгсэл ОО душ угаагууруудыг салган авч буцаан угсрах гм жил бүр дахин давтагдсан үргүй зардлуудыг гаргаж байгаа ч бороо их орсны дараа ахин ус гоожиж хийсэн бүх ажил үр дүнгүй болж байгаа тул цаашид Монгол Шилтгээн ХК нь ийм аргацаасан байдлаар ажиллах ямар ч бололцоогүй болоод байна.

Үйл ажиллагаа явуулахгүй, орлого олохгүй байгаагаас үл хамааран Газар, Үл хөдлөх хөрөнгө, НДШ, Хөрөнгийн бирж, Үнэт Цаасны хадгаламжийн хураамжууд, сахиулын зардал, санхүү, аудитын гэх мэт зардлууд төлөгдөх ёстой болдог нь манай компаний хувьд өмнөх зээлээ төлсөн боловч ахин зээл авахаас аргагүй байдалд хүргэж байна.

Рестораны хувьд гадна тал нь нурж унасан байдалтай, засвар хийхэд их хөрөнгө шаардагдахаар, бас л ялгаагүй ус гоождог, чийгтэй мөөгөнцөртсөн байдалтай байгаагаас гадна яг хурим найр ид болдог 9-р сард их хүйтэн болдог тул ажиллуулж хүн хүлээн авч хурим найр хийх боломжгүй.

Ажиллах хүчний хувьд мэргэжлийн хүмүүс олдохгүй, өдрөөр хүмүүс ажиллуулан, Санхүүгийн компани, Security хамгаалалтын компаниудтай гэрээтэй ажиллалаа.

Монголд шинээр олон амралтын газрууд, кемпүүд стандартын өндөр түвшинд шинээр баригдаж хийгдэж байгаа энэ цаг үед Монгол Шилтгээн бүх талаараа хуучирч элэгдэн хүмүүст

гологдож байгаа тул цаашид цаг агаараас хамааралгүй 4 улиралд ажиллаж болох шинэ зочид буудал барихаас өөр аргагүй болоод байгаа болно.

Гачуурт тосгоны хувьд дулаан, ус, бохир гм дэд бүтцийн асуудал шийдэгдээгүй байгаа нь хөрөнгө оруулахад одоогоор хүндрэлтэй байгаа болно.

2025 оны хувьд гэрүүдээ түрээслэн шинээр шоу арга хэмжээнүүдийг авч орлогоо нэмэгдүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

Монгол Шилтгээн ХК-ий хувьд шинээр зочид буудал барих төслийг эхлүүлэхийн тулд ахин зээл авах эсвэл хувьцаа гаргаж шинээр хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлага үүсээд байгаа болно.

Санхүү мэдээ борлуулалт

2024 онд

Гэрийн түрээсийн орлого 54 . 581 818 18 төгрөг

Нийт үйл ажиллагааны зардал 118. 073 033.45 төгрөг

Санхүүгийн тайлан, танилцуулга материалд тусгагдсан байгааг товч танилцуулав.

/Хавсралтаар/ хуралд оролцогч нарт хурлын материал тараав

“Монгол шилтгээний барилгад засвар үйлчилгээ хийх томоохон ажлууд байна гэж Гүйцэтгэх захирал М.Ган-Эрдэнэ товч танилцуулав.

Хуралд ТУЗ-ийн хараат бус гишүүд: А.Ариунсайн, Ж.Жаргалсайхан, М.Отгонбаатар нар оролцлоо.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Жаргалсайхан:

Цаашид “Монгол шилтгээн” ХК нь зөвхөн зуны 3 сарын үйл ажиллагааны орлого хараад л байх юм бол бид энэ нөхцөл байдлаасаа гарч чадахгүй. Тиймээс компанийн үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулан цаашид барилга барих, зочид буудал байшин барилгаа засаж сайжруулах талаас нь шинээр үйл ажиллагааны чиглэлдээ нэмэлт оруулах талаар санал дэвшүүлэн энэхүү асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх санал дэвшүүлэв. ТУЗ-ийн хараат бус гишүүд саналыг дэмжиж оролцлоо.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай хэмээн үзсүгэй.
2. “**Монгол шилтгээн**” ХК-ийн 2024 онд алдагдалтай ажилласантай холбогдуулан ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосон ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулав.
3. 2025 онд бизнесийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигтай ажиллах талаар идэвх санаачлага гарган ажиллахыг Гүйцэтгэх захирал М.Ган-Эрдэнэд даалгасугай.

Хурал хэсэг засварласаны дараа Тооллогын комиссын дарга С.Дагиймаа , гишүүн Г.Төрбаяр нар саналын хуудасыг тоолж танилцуулав.

Хурал зохион байгуулах комиссын дарга С.Энхтуяа хурлаас гарсан шийдвэр, тогтоолын төслийг уншиж танилцуулснаар хурал амжилттай өндөрлөв.

Хурал 17.30 –д өндөрлөв.

Хурал удирдсан хурлын дарга: / Ч.Амарбаатар /

Протокол бичсэн: / С.Энхтуяа /